

## Гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн орчин

Чуулга уулзалтад оролцогч та бүхний энэ өдрийн амгаланг эрж мэндчилье.

Өмчийн олон хэлбэр ялангуяа хувийн өмчийг зөвшөөрдөггүй байсан төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжин орсон 1990-ээд оны үеэс гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих бодлогыг Монгол Улсын төр тавьж ирсэн билээ. Юуны өмнө 1992 онд баталсан Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлд “Монгол Улс дэлхийн эдийн засгийн түгээмэл хандлага, өөрийн орны онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна. Төр нь хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна” гэж заасан.

Үндсэн хуулийн үзэл санаа болоод төрийн бодлогын илэрхийлэл болсон бусад хууль тогтоомждоо гадаадын хөрөнгө оруулагчдад тааламжтай нөхцөл, боломж олгох зохицуулалтуудыг тусгах замаар эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх бодлогоо хэрэгжүүлж байна

Шинэ Үндсэн хуулийн дараа “Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалтыг урамшуулан дэмжих, хөрөнгө оруулагчийн эрх, эд хөрөнгийг хамгаалах болон гадаадын хөрөнгө оруулалтын холбогдолтой харилцааг зохицуулах” зорилт бүхий Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийг 1993 онд батлан 13 дахь жилдээ мөрдөж байна.

Энэ хуульд гадаадын хөрөнгө оруулалтын талаархи үндсэн гол зарчмын асуудлуудыг тусгасан юм. Тухайлбал уг хуулийн 9 дүгээр зүйлд гадаадын хөрөнгө оруулагчид оруулсан хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулахад нь Монгол улсын аж ахуйн нэгж байгууллагатай адил нөхцөл олгоно гэж заасан юм. Түүнчлэн зөвхөн хуулиар хориглосон үйлдэрлэл, үйлчилгээнээс бусад бүх салбарт хөдлөх, үл хөдлөх хөрөнгө, чөлөөтэй хөрвөх валют, оюуны болон аж үйлдвэрийн өмчийн эрх зэрэг хэлбэрээр Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалтыг чөлөөтэй оруулж болох юм.

Гадаадын хөрөнгө оруулагчдын хөрөнгийг хууль бусаар хураан авахыг хориглох, хуульд заасан үндэслэлээр дайчлан авах тохиолдолд нөхөн төлбөрийг саадгүй төлөх зэрэг эрх зүйн баталгааг нь тодорхой тусгасан байна. Гадаадын хөрөнгө оруулагч нь өөрийн хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийг удирдах, өөрийн оруулсан эд хөрөнгөө гадаадад чөлөөтэй буцаан гаргах, тус улсын нутаг дэвсгэрт олсон орлого, ашгаа саадгүй гуйвуулах зэрэг эрхээр хангагдана.

Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуульд заасны дагуу тус улсад 2 сая америк доллар буюу түүнээс дээш хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн гадаадын хөрөнгө оруулагчтай үйл ажиллагаагаа тогтвортой явуулах эрх зүйн баталгаа болгон Монгол Улсын Засгийн газар Тогтвортой байдлын гэрээ байгуулахаар тусгасан. Энэхүү гэрээний дагуу тухайн этгээдийн үйл ажиллагаагаа эхлэх үед баримталж байсан татвар, төлбөрийн хувь хэмжээг тогтвортой хадгалах, буюу

нэмэгдүүлэхгүй байх үүргийг Засгийн газар хүлээдэг. Өөрөөр хэлбэл энэ нь гадаадын хөрөнгө оруулалтыг эрсдэлээс хамгаалах орчин болж байна.

Гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн орчинг боловсронгуй болгох зорилгоор УИХ энэ хуульд 2001, 2002 онудад нэмэлт оруулсан. Эдгээр нэмэлтээр гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийг бүртгэх, татан буулгах, зарим үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, үйл ажиллагаатай нь холбогдсон дүгнэлт гаргах зэрэг янз бүрийн шатны олон байгууллага өөр өөр газар олгодог байснаас хүндрэл учруулах, чирэгдүүлж байсныг өөрчилж Гадаад хөрөнгө оруулалт, гадаад худалдааны асуудал эрхэлсэн Засгийн газрын агентлагийг байгуулж бүх үйлчилгээг нэг цэгээс үзүүлдэг тогтолцоонд шилжсэн юм. Мөн заавал бие даасан хуулийн этгээд байгуулалгүйгээр концесс, бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах, санхүүгийн түрээс эрхлэх зрх авах, байгалийн баялагийг ашиглах, боловсруулах төсөл хэрэгжүүлэх зэрэг хэлбэрээр хөрөнгө оруулалтын хүрээг өргөжүүлэх чиглэлийн нэмэлт оруулсан.

Гадаадын хөрөнгө оруулагч дотоодын аж ахуй эрхлэгчидтэй нэгэн адил эрх эдлэх зарчим үйлчилдэг тухай дээр дурдсан билээ. Иймд татварын, гаалийн, аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн, эрчим хүч, харилцаа холбоо, байгаль орчин, хөдөлмөр эрхлэлт гэх мэт салбарын бусад хууль тогтоомжууд нь гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн орчинг бүрдүүлж байгаа юм. Тэргүүлэх ач холбогдол бүхий салбарт гадаадын хөрөнгө оруулалт хийхэд тухайн үйлдвэрлэлд шаардагдах тоног төхөөрөмж болон газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээний үндсэн дээр оруулж ирж буй машин механизм, бараа материалыг гаалийн болон аж ахуйн нэгж, байгууллагыгн татвараас чөлөөлөх зэргээр зарим хөнгөлөлтийг эдлүүлж төрөөс тэдний үйл ажиллагааг дэмжиж байна. Дэмжлэг үзүүлэх салбарын жагсаалтыг Монгол Улсын Засгийн газар тогтоодог.

Энд дурдах хоёр дахь том асуудал бол олон улсын гэрээний асуудал юм. Монгол Улсын Үндсэн хуульд олон улсын гэрээ хүчин төгөлдөр болмогцоо Монгол Улсын хуулийн нэгэн адил үйлчилнэ гэж заасан юм. Дэлхийн худалдааны байгууллага байгууллага багуулах тухай Марракешийн хэлэлцээр, Хөрөнгө оруулалтыг баталгаажуулах олон талт агентлагийг үүсгэн байгуулах Конвенци, Гадаад арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай Конвенци, Улс болон гадаад улсын иргэний хооронд хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх тухай Конвенци зэргийг нэрлэж болох байна.

Эдгээр гэрээ, конвенцийн гол үзэл санаа нь тэгш харилцан ашигтай байх үндсэн дээр олон улсын худалдааг хөгжүүлэх, эдийн засгийг хөгжүүлэх олон талт хамтын ажиллагааг бэхжүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтад арилжааны бус эрсдэлээс хамгаалах, хөгжиж буй орнуудад хийгдэж буй хөрөнгө оруулалтыг дэмжих, түүнчлэн хэлэлцэн тохирогч талууд маргаанаа олон улсын арга хэрэгсэл хэрэглэн зохицуулах, хэлэлцэн тохирогч улсын нутаг дэвсгэрт гаргасан арбитрийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөхөд чиглэгдсэн байна.

Эдгээр гэрээ, хэлэлцээр, конвенцид нэгдэн орснор Монгол Улс олон улсын өмнө гадаадын хөрөнгө оруулалтыг баталгаажуулахад чиглэсэн тодорхой үүрэг, хариуцлага, хүлээж байгаа хэрэг юм. Мөн түүнчлэн тус улс нь 40 орчим улстай давхар татвар ногдуулахгүй байх гэрээг байгуулсан байна.

Хууль зүй, дотоод хэргийн яамны тухайд Монгол Улсын эрх зүйн бодлогыг боловсруулах, үндэсний хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиг үүргийнхээ хүрээнд хууль тогтоомжийн төслийг боловсруулах, хянах явцдаа Үндсэн хуулийн үзэл баримтлал хийгээд олон улсын эдийн засгийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэхийг зорьж ажилладаг билээ.

Гадаадын хөрөнгө оруулалтыг төдийгүй дотоодын аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхүйц хууль тогтоомжийг боловсруулан гаргахад дэмжлэг үзүүлэх, ялангуяа хүний эрх, эрх чөлөө, аюулгүй байдлыг хангах, төрийн албаны үйлчилгээг үр дүнтэй хүртээмжтэй, ил тод, нээлттэй болгох, сонирхол нь хөндөгдөж тал болон иргэдийн саналыг харгалзан үзэх зэрэгт илүү анхааран ажиллаж байгаа цохон тэмдэглэж байна. Тухайлбал, Ашигт малтмалын тухай, Татварын багц хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Авилгын эсрэг хууль хуулийг боловсруулах санал дүгнэлт өгөх хэлбэрээр оролцсон юм. Мөн хуулийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ашгийн бус хуулийн этгээдийн тухай, Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг энэ онд боловсруулж байна. Мөн түүнчлэн Монгол Улсын сайд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг даргын нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан дүрэм, журмыг хянаж улсын бүртгэлд бүртгэхдээ дээр дурдсан зарчмыг бас баримтлан ажилладаг юм.

Монгол Улс гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих, хөгжүүлэх эрх зүйн таатай орчин бүрдүүлэхэд чиглэсэн бодлого баримталж байгааг цухас дурдахад ийм байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.